

**Golomt Capital<sup>®</sup>**

# ДЭЛХИЙН

---

**ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО  
ХОНОГИЙН ТОЙМ**

**2025.09.08**

## Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ

### ТОВЧ

- Баасан гарагийн орой манай цагаар 20:30 минутанд гарсан мэдээлэл хүлээлтээс доогуур гарч ХНС богино хугацааны хүүгээ бууруулна гэсэн хүлээлт нэмэгдэж зах зээл өсөлттэй эхэлсэн.
- АНУ-ын ажил олгогчид наймдугаар сард ердөө 22,000 ажлын байр шинээр нэмсэн нь долдугаар сарын 79,000-тай харьцуулахад эрс буурч, мөн шинжээчдийн 77,000 гэсэн хүлээлтээс доогуур гарчээ.
- Шинжээчид Хятадын зах зээлийн сүүлийн өсөлтийг хүүгийн түвшин бага, сонирхол татахуйц хөрөнгө оруулалтын боломж цөөн үед өндөр өгөөж хайж буй мөнгөний илүүдэлтэй айл өрхүүдтэй холбон тайлбарлаж байна.
- Олон эдийн засагчид ирэх саруудын мэдээллээр Хятадын өсөлтийн саарах магадлалтайг анхааруулж байна.



### S&P 500 индексийн 2025 оны таамаглал

Deutsche Bank	7,000
Société Générale	6,750
BMO Capital Markets	6,700
Bank of America	6,666
Barclays	6,600
RBC Capital Markets	6,600
Wells Fargo	6,500
Citigroup	6,500
Goldman Sachs	6,500
Morgan Stanley	6,500
JPMorgan Chase	6,500
UBS	6,400
<b>Дундаж</b>	<b>6,678</b>





## АНУ-ын зах зээлийн онцлох мэдээ 2025.09.01-09.07


### АНУ-ЫН БОДЛОГЫН ХҮҮ БУУРНА.

Өнгөрсөн долоо хоногийн хамгийн чухал үйл явдал АНУ-ын хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл байлаа. Баасан гарагийн орой манай цагаар 20:30 минутанд гарсан мэдээлэл хүлээлтээс доогуур гарч ХНС богино хугацааны хүүгээ бууруулна гэсэн хүлээлт нэмэгдэж зах зээл өсөлттэй эхэлсэн ч арилжаа сүүлийн хагаст эдийн засгийн өсөлтийг дэмжихэд хөдөлмөрийн зах зээл хангалтгүй байж болзошгүй гэсэн болгоомжлол нэмэгдсэнээр хувьцааны зах зээл хүчтэй уналтыг үзүүлсэн.

Энэ тайланд АНУ-ын ажил олгогчид наймдугаар сард ердөө 22,000 ажлын байр шинээр нэмсэн нь долдугаар сарын 79,000-тай харьцуулахад эрс буурч, мөн шинжээчдийн 77,000 гэсэн хүлээлтээс доогуур гарчээ. Зургадугаар сарын тоо ч мөн доошоо өөрчлөгдөж, өмнө нь +14,000 гэж байсан бол -13,000 болсон нь 2020 оны арванхоёрдугаар сараас хойших анхны сөрөг сарын үзүүлэлт болов. Наймдугаар сарын ажилгүйдлийн түвшин 4.3%-д хүрч, 2021 оноос хойших хамгийн өндөр түвшинд хүрэв. Хувийн хэвшлийн ADP-ийн ажлын байрны тайлан ч мөн адил чиг хандлагыг илтгэж, наймдугаар сард 54,000 ажлын байр нэмэгдсэн нь өмнөх сарын 106,000-аас буурч, мөн 80,000 гэсэн хүлээлтээс доогуур байлаа. Үүний зэрэгцээ Хөдөлмөрийн яам долдугаар сарын ажлын байрны сул орон тоо 7.18 сая болж, 2024 оны есдүгээр сараас хойших хамгийн бага түвшинд хүрсэн гэж мэдээлсэн бөгөөд ажилгүй иргэдийн тоо нь ажлын байрны сул орон тооноос анх удаа 2021 оноос хойш давлаа. Баасан гарагийн үдээс хойши байдлаар CME FedWatch хэрэгслийн тооцооллоор Холбооны Нөөцийн Сан (ФРС) дараагийн хурлаараа дор хаяж 25 суурь нэгжийн (0.25 хувь) хүү бууруулах магадлал 100% болсон бол 50 суурь нэгжээр бууруулах магадлал 0%-иас 10% хүртэл өссөн байна. Энэ долоо хоногийн турш буурах чиг хандлагатай байсан АНУ-ын төрийн сангийн өгөөжүүд Баасан гарагт огцом унаж, 10 жилийн хугацаатай төрийн сангийн бондын өгөөж дөрөвдүгээр сарын эхнээс хойших хамгийн доод түвшинд хүрэв.

Golomt\_Capital created with TradingView.com, Aug 31, 2025 23:29 UTC-4

NASDAQ 100 E-mini Futures - 1M - CME Q23,479.00 H23,552.50 L23,433.75 C23,443.75 -10.75 (-0.05%) -10.75 (-0.05%)



## Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ 2025.09.01 – 09.07

### ХЯТАДЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨСӨЛТ СААРМАГЖИЖ ЭХЭЛЛЭЭ.

Эх газрын Хятадын хөрөнгийн зах зээлд сүүлийн өдрүүдийн өсөлтөөс ашиг хүртэх зорилгоор хөрөнгө оруулагчид хувьцаагаа зарсантай холбоотойгоор бууралт ажиглагдлаа. FactSet-ийн мэдээлснээр, дотоодын CSI 300 индекс 0.81%-иар, Шанхайн нийлмэл индекс 1.18%-иар (орон нутгийн валютаар) тус тус унасан байна. Харин Хонгконгийн Hang Seng индекс 1.36%-иар өсжээ.


Хятадын хөрөнгийн зах зээл дөрөвдүгээр сараас хойш өссөн бөгөөд энэ нь ихэвчлэн компанийн ашиг орлого эсвэл эдийн засгийн сэргэлтээс бус, дотоодын хөрвөх чадвараас хамаарсан гэж үзэж байна. CSI 300 индекс наймдугаар сард 10%-иар өссөн нь өнгөрсөн сардууд бодлогоор дэмжсэний үр дүн юм. Тус индекс энэ оны хамгийн доод цэгээс 20 гаруй хувиар өссөн байна. Наймдугаар сард дундаж арилжааны хэмжээ түүхэн дээд түвшинд хүрч, өнгөрсөн долоо хоногт маржин арилжааны үлдэгдэл хэмжээ дээд түвшинд хүрсэн нь жижиг хөрөнгө оруулагчдын эрсдэл хүлээх дуршил өндөр байгааг Bloomberg мэдээлжээ.

Хятадын хиймэл оюун ухааны хөгжил, салбар бүрт хэт өрсөлдөөн, үнэ буулгах дайныг зогсоох зорилготой төрийн тэргүүлсэн “эсрэг-инволюци” кампанит ажил нь хөрөнгө оруулагчдын өөдрөг үзэлд түлхэц болж байна. Мөн шинжээчид сүүлийн өсөлтийг хүүгийн түвшин бага, сонирхол татахуйц хөрөнгө оруулалтын боломж цөөн үед өндөр өгөөж хайж буй мөнгөний илүүдэлтэй айл өрхүүдтэй холбон тайлбарлаж байна.

Гэвч эдийн засгийн үзүүлэлтүүд өргөн хүрээтэй удаашрал үргэлжилж буйг харуулсаар байгаа бөгөөд АНУ-ын тарифын өсөлт, олон жил үргэлжилж буй үл хөдлөх хөрөнгийн уналт, мөн удаан үргэлжилсэн дефляци нь эрсдэл дагуулж байна. Олон эдийн засагчид ирэх саруудын мэдээллээр Хятадын өсөлтийн сааралт баталгаажиж, улмаар АНУ-ын өдөөсөн худалдааны дайны дунд төрөөс эдийн засгаа хамгаалахын тулд илүү их төсвийн болон мөнгөний урамшууллын арга хэмжээ авч эхэлнэ гэж үзэж байна.

Golomt\_Capital created with TradingView.com, Aug 31, 2025 23:28 UTC-4

Hang Seng Index Futures - 1M - HKEEX Q25,025 H25,597 L24,877 C25,545 -522 (-2.09%) -522 (-2.09%)



**Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд**

Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open
		NIO	ZS	DLTR	CRM	FLWS	AVGO	ABM
		SIG	zscaler	DOLLAR TREE	salesforce	flowers.com	BROADCOM	
		SIGNET	HOY	MI	CRDO	SHOE CARNIVAL	LULU	
		Academy	HealthEquity	macy's	CREDO	TTC	DocuSign	
				Campbell's	C3.ai	TORO	Path	
				RV	AMERICAN EAGLE OUTFITTERS	AMERICA'S CAR-MART	UiPath	
				sprinklr	GitLab	ciena	samsara	
				J.Jill	Hewlett Packard Enterprise	endava	braze	
				Polestar	Figma	GIII	Copart	
					asana	VersaBank	Quanex	
					PagerDuty	SAIC	Smith & Wesson	
					-chargepoint-	WILEY	ServiceTitan	

<http://eps.sh/cal> © 2025 Earnings Whispers

**Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд**

Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open
planet.	Casey's	SAIL	ORCL	chewy	zenvia	Kroger	Adobe	
ABVX	ABIVAX	MOMO	GameStop	DAKT	OXFORD	LOVESAC	Farmer Brothers	
AVO	Mission	FCEL	AVAV	DAKTRONICS	LSAK	KalVista	INDUSTRIES	
MAMA	Mama's Creations	CNM	AeroVironment	TEN LTD	CULP	HOOKER	kestra	
		CORE & MAIN	SYNOPSIS	TENOR ENERGY	VINCE.	Vera Bradley		
		KFY	rubrik					
		KORN FERRY	LANDS' END					
		DESIGNER BRANDS	LIMONEIRA					
		Cognyte	METHODE ELECTRONICS					
		SHOULDER	Calavo					
		Bioceres	AMRK					
		Group Solutions	A-MARK PRECIOUS METALS, INC.					

<http://eps.sh/cal> © 2025 Earnings Whispers